



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 514

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Налайх-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 70,640,000.00 (далан сая зургаан зуун дөчин мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан биет бус хөрөнгө (4000 м.кв газар эзэмших эрх)-ийг "Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын төв" улсын төсөвт үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. "Налайх-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ч.Ренчиндамба, гүйцэтгэх захирал Ц.Баттулга, "Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын төв" улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал А.Буяннэмэх нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэст үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бөдлөг,
 зохицуулалтын газрын 2020 оны 10
 дугаар сарын 20-ны өдрийн 514
 дүгээр тогтоолын хавсралт

"Налайх-АЗЗА" ТӨХК-ийн эргэлтийн бус хөрөнгөд бүртгэлтэй "Галт
 тэрэгний хөдлөгөөн зохицуулалтын төв УТҮГ-т шилжүүлэх хөрөнгийн
 жагсаалт

Д/ д	Үндсэн хөрөнгийн нэр, байршил	Ашигла лтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэм жээ	Балансын нийт үнэ (төгрөг)
1	Биет бус хөрөнгө, газар эзэмших эрх (Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо)	2019	м.кв	4000	70,640,000.00
	Нийт дүн				70,640,000.00 (далан сая зургаан зуун дөчин мянган)